



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Шүүх шинжилгээний ерөнхий газрын харьяа Баянхонгор аймгийн Шүүх шинжилгээний хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, хавсралтад заасан нийт 1,246,793,202.67 (нэг тэрбум хоёр зуун дөчин зургаан сая долоон зуун ерэн гурван мянга хоёр зуун хоёр төгрөг жаран долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг Стандарт, хэмжил зүйн газрын харьяа Баянхонгор аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтэст балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН